



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/111

Чойбалсан

Г Шинэ төрлийн коронавирусийн халдварын Г
болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх
арга хэмжээг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "а", 29.1.5 "а", 29.1.6 "а", Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 10.5, 32 дугаар зүйлийн 32.1, 33 дугаар зүйлийн 33.1, 34 дүгээр зүйлийн 34.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 10 дугаар зарлиг, Монгол Засгийн газрын 2020 оны 62 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2020 оны 04 дүгээр тушаал, Онцгой байдлын Ерөнхий газрын даргын 2018 оны А/274 дүгээр тушаал, аймгийн Онцгой комиссын 2020 оны 10 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шинэ коронавирусийн халдвар /COVID 2019/-ын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор 2020 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс мөн оны 03 дугаар сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах Эрүүл мэндийн албыг ажлын тусгай горимд шилжүүлэн ажиллуулсугай.

2.Гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, хүч хэрэгслийг томилгоожуулан, бэлтгэл бэлэн байдлыг хангаж ажиллахыг Бүсийн төв Онцгой байдлын газар /хурандаа Г.Нармандах/, сумын Засаг дарга, гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн ангийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Гамшгийн үеийн нөөцийг тухайн шатны Засаг даргын зөвлөл болон тухайн шатны Онцгой комиссын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж байхыг Бүсийн төв Онцгой байдлын газар /хурандаа Г.Нармандах/, сумын Засаг дарга нарт тус тус үүрэг даалгасугай.

4.Шинэ төрлийн коронавирусийн халдвараас /COVID 2019/ урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулахтай холбоотой мэдээ мэдээллийг дараалал харгалзахгүй дамжуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах, мөн улсын Онцгой комисс, Онцгой байдлын ерөнхий газар, сумын Онцгой комисстой холбогдох мэдээ, мэдээллийг тогтмол солилцож, аймгийн Онцгой комиссын дарга, аймгийн Засаг даргад тухай бүр танилцуулж ажиллахыг аймгийн Онцгой комиссын орлогч дарга, аймгийн Засаг даргын орлогч /Ч.Ганбат/-д үүрэг болгосугай.

010120323

5.Цагаан сарын баяртай холбогдуулан бараа бүтээгдэхүүний зар сурталчилгаа явуулахыг зогсоож, шинэ төрлийн коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх сурталчилгаа мэдээллийг иргэдэд шуурхай хүргэж ажиллахыг орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа хэвлэл мэдээллийн байгууллагуудад даалгасугай.

6.Хот хоорондын нийтийн болон агаарын тээврийн хэрэгслээр зорчиж байгаа зорчигчдын эрүүл мэндийн байдалд хяналт тавих, тээврийн хэрэгсэлд халдваргүйтгэл хийхийг аймгийн Автотээврийн төв /Ц.Мөнхтөр/, Чойбалсан Олон улсын нисэх буудал /М.Энхтөр/, Эрүүл мэндийн газар /Ч.Оюунаа/, Мэргэжлийн хяналтын газар/ Д.Мөнхтуяа/-т тус тус даалгасугай.

7.Иргэд, олон нийтийг хамарсан үзэсгэлэн худалдаа зохион байгуулахгүй байхыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар /Ж.Алимаа/, Худалдаа аж үйлдвэрийн танхим /Э.Адъяа/, сумын Засаг дарга, аж ахуйн нэгж, худалдаа үйлдвэрлэл эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

8.Аймгийн хэмжээнд шашин номын хурал, цуглаан, зан үйлд иргэд олон нийтийг оролцуулахгүй байх арга хэмжээ авахыг аймгийн нийт Шашны байгууллагуудад зөвлөсүгэй.

9.Шинэ төрлийн коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн байгууллагуудын өгч буй зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх, иргэний үүргээ ухамсарлан нийтийн болон өөрийн эрх ашгийг эрхэмлэхийг нийт ард иргэдэд уриалсугай.

10.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ч.Ганбат/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.БАДАМСҮРЭН